



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/118/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Аудитор: П. Ганцолмон
	Утас: 70157405 Цахим хаяг: ulistaivanaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	14
4.2 Төлбөрийн акт	14
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж.....	14
4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 04.25 № 133

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу хөтлөөгүй, тооцоо бодоогүй, нийгмийн даатгалын тайланг тооцоолсон цалингаас дутуу тайлагнасан нь, 2020 онд акталсан тавилга эд хогшил дахин актлуулах санал өгч, ИТХ-ын тогтоол гаргуулсан, ажилтанд үр дүнгийн урамшуулал тушаал шийдвэргүй олгосон зэрэг материаллаг 10.2 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
АЛТАЙ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ЧАМИНЦЭЦЭГ ТАНАА

07020399

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,073,973.68	31,635,913.50
33	АВЛАГА	1,034,010.88	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,034,010.88	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	38,039,962.80	31,635,913.50
35100	Түүхий эд материал	26,500.00	0.00
35130	Эм боох материал	26,500.00	0.00
35400	Хангамжийн материал	38,013,462.80	31,635,913.50
35410	Бичиг хэргийн материал	701,000.00	701,000.00
35440	Түлш, шатах тослох материал	293,400.00	0.00
35460	Хүнсний материал	1,345,916.00	3,577,647.50
35470	Бусад хангамжийн материал	35,673,146.80	27,357,266.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	126,859,335.03	111,570,116.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	126,859,335.03	111,570,116.55
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	120,926,835.03	105,637,616.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	97,235,981.50	97,235,981.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,005,527.10)	(21,008,290.66)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	23,585,700.00	23,250,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,457,700.26)	(11,319,898.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,168,443.99	35,617,658.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,058,862.10)	(18,597,333.66)
39217	Ном	458,799.00	458,799.00
39300	Биет бус хөрөнгө	5,932,500.00	5,932,500.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(37,500.00)	(37,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,670,000.00	5,670,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	165,933,308.71	143,206,030.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,000.00	30,736.69
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,000.00	30,736.69
41300	Өглөг	7,000.00	30,736.69
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,000.00	2,736.69
41360	Бусад өглөг	0.00	28,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	28,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	165,926,308.71	143,175,293.36
51	Засгийн газрын хувь оролцоо	165,926,308.71	143,175,293.36
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	73,719,877.13	73,719,877.13
51200	Хуримтлагдсан үр дүн	(10,794,902.89)	(33,545,918.24)
51210	Өмнөх үеийн үр дүн	563,739.14	(10,794,902.89)
51220	Тайлант үеийн үр дүн	(11,358,642.03)	(22,751,015.35)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	103,001,334.47	103,001,334.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	165,933,308.71	143,206,030.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	291,277,270.99	263,773,330.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,839,070.99	1,592,730.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,839,070.99	1,592,730.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,839,070.99	0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,839,070.99	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	587,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	1,005,730.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	282,438,200.00	262,180,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	269,222,200.00	246,974,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	269,222,200.00	246,974,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,216,000.00	15,206,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,216,000.00	15,206,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	302,635,913.02	286,524,345.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	302,635,913.02	286,524,345.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	259,171,210.02	274,675,809.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,317,095.62	182,561,702.69
210101	Үндсэн цалин	160,936,966.36	154,416,801.69
210104	Урамшуулал	8,352,074.26	13,244,711.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,028,055.00	14,900,190.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,401,332.99	29,205,354.94
210201	Тэтгэврийн даатгал	17,430,352.99	20,345,086.48
210202	Тэтгэмжийн даатгал	472,500.00	2,153,674.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,480,626.00	1,722,203.56
210204	Ажилгүйдлийн даатгал	372,077.00	429,529.72
210205	Эрүүл мэндийн даатгал	3,645,777.00	4,554,861.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,335,480.00	15,885,354.50
210301	Гэрэл, цахилгаан	296,480.00	893,154.50
210302	Түлш, халаалт	13,039,000.00	14,992,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,374,690.00	15,479,080.80
210401	Бичиг хэрэг	230,300.00	656,650.00
210402	Тээвэр, шатахуун	3,257,450.00	4,052,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	656,000.00	248,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	902,600.00
210408	Бараа материал акт алсны зардал	5,710,940.00	9,618,880.80
2105	Нормативт зардал	14,436,784.00	13,265,148.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	144,000.00	751,280.00
210502	Хоол, хүнс	14,078,184.00	12,402,868.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	214,600.00	111,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	179,000.01	160,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	179,000.00	160,000.00
210604	Урсгал засвар	0.01	0
2107	Томилолт, зочны зардал	0	460,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0

Говь-Алтай аймгийн Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,377,200.00	1,713,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	833,200.00	1,065,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,749,627.40	15,945,968.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	712,100.00	69,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,037,527.40	15,876,218.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,464,703.00	11,848,535.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,296,000.00	1,440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,296,000.00	1,440,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	612,520.00	2,095.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	612,520.00	2,095.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,556,183.00	10,406,439.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,556,183.00	10,406,439.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-11,358,642.03	-22,751,015.35
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-11,358,642.03	-22,751,015.35

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,719,877.13	103,001,334.47	578,541.34	177,299,752.94
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-14,802.20	-14,802.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	73,719,877.13	103,001,334.47	563,739.14	177,284,950.74
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-11,358,642.03	-11,358,642.03
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,719,877.13	103,001,334.47	-10,794,902.89	165,926,308.71
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	73,719,877.13	103,001,334.47	-10,794,902.89	165,926,308.71
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	73,719,877.13	103,001,334.47	-10,794,902.89	165,926,308.71
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-22,751,015.35	-22,751,015.35
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	73,719,877.13	103,001,334.47	-33,545,918.24	143,175,293.36

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	284,284,365.00	262,180,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	284,154,866.00	262,180,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	284,154,866.00	262,180,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	240,690,163.00	250,332,064.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,317,769.00	181,531,955.12
210101	Үндсэн цалин	158,011,240.00	153,387,054.12
210104	Урамшуулал	12,278,474.00	13,244,711.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,028,055.00	14,900,190.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	23,401,333.00	29,205,354.94
210201	Тэтгэврийн даатгал	17,430,353.00	20,345,086.48
210202	Тэтгэмжийн даатгал	472,500.00	2,153,674.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,480,626.00	1,722,203.56
210204	Ажилгүйдлийн даатгал	372,077.00	429,529.72
210205	Эрүүл мэндийн даатгал	3,645,777.00	4,554,861.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,603,480.00	15,204,204.50
210301	Гэрэл, цахилгаан	296,480.00	1,014,004.50
210302	Түлш, халаалт	12,307,000.00	14,190,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,371,081.00	5,538,700.00
210401	Бичиг хэрэг	325,400.00	330,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,257,450.00	4,320,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,183,230.00	248,700.00
210404	Ном, хэвлэл	1	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	205,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	400,000.00
2105	Нормативт зардал	14,637,300.00	15,412,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	170,500.00	650,000.00
210502	Хоол, хүнс	14,197,700.00	14,062,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	269,100.00	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	240,000.00	240,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.00	240,000.00
2107	Томилолт, зочны зардал	0	460,000.00
210702	Дотоод албан томилолт	0	460,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,377,200.00	1,685,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	833,200.00	1,037,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	742,000.00	1,054,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,000.00	1,054,100.00

Говь-Алтай аймгийн Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,464,703.00	11,848,535.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,296,000.00	1,440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,296,000.00	1,440,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	612,520.00	2,095.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	612,520.00	2,095.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,556,183.00	10,406,439.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,556,183.00	10,406,439.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	129,499.00	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	129,499.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	129,499.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	129,499.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	129,499.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-129,499.00	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	262,180,600.00	251,772,064.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,180,600.00	251,772,064.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	260,740,600.00	250,332,064.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,068,500.00	181,531,955.12
210101	Үндсэн цалин	156,831,200.00	153,387,054.12
210104	Урамшуулал	17,969,600.00	13,244,711.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,267,700.00	14,900,190.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,581,200.00	29,205,354.94
210201	Тэтгэврийн даатгал	20,613,100.00	20,345,086.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,136,200.00	2,153,674.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,708,900.00	1,722,203.56
210204	Ажилгүйдлийн даатгал	426,300.00	429,529.72
210205	Эрүүл мэндийн даатгал	4,696,700.00	4,554,861.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,206,300.00	15,204,204.50
210301	Гэрэл, цахилгаан	1,014,100.00	1,014,004.50
210302	Түлш, халаалт	14,192,200.00	14,190,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,770,000.00	5,538,700.00
210401	Бичиг хэрэг	330,000.00	330,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,320,000.00	4,320,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	480,000.00	248,700.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	400,000.00
2105	Нормативт зардал	16,552,500.00	15,412,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	650,000.00	650,000.00
210502	Хоол, хүнс	15,202,500.00	14,062,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	240,000.00	240,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.00	240,000.00

2107	Томилолт, зочны зардал	580,000.00	460,000.00
210702	Дотоод албан томилолт	580,000.00	460,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,688,000.00	1,685,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,040,000.00	1,037,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,054,100.00	1,054,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,054,100.00	1,054,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,440,000.00	1,440,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,440,000.00	1,440,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,440,000.00	1,440,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	262,180,600.00	251,772,064.56
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	246,974,300.00	236,567,860.06
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	246,974,300.00	236,567,860.06
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,206,300.00	15,204,204.50
320001	Орон нутгийн төсвөөс	15,206,300.00	15,204,204.50

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Аудитын "Улиастай ван аудит" ХХК-ийн аудитор П.Ганцолмон гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сургалтын амжилт чанар, хөгжил төлөвшилтийг сайжруулан хоцрогдолгүй сургах, эрүүл аж төрөх амьдралын зөв хэв маяг, бие даан суралцах чадвар эзэмшүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийн тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлж ажиллах зорилго дэвшүүлж ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 230.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 286.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16 хувиар буюу 22.7 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Аудитын код ГАА-2022/118/-НА-СТА-ТШЗ



Бараа материалын дансны үлдэгдэл 31.6 сая төгрөг болж 6.4 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш шатахуун, хүнсний материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 36.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 1.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 34.7 сая төгрөгийн материалыг зарцуулж, 9.6 сая төгрөгийн хөрөнгийг бусдаар зарцуулж, данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 162.5 сая төгрөг болж 0.9 сая төгрөгөөр буурсан нь 0.6 сая төгрөгийн хөрөнгө хандиваар авч, 1.5 сая төгрөгийн хөрөнгө акталж устгасантай холбоотой

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 143.2 сая төгрөг болж 22.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 5.5 хувиар буюу 16.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь санхүүжилт болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -33.5 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 785.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 523.0 сая төгрөгөөр бууруулж, 262.2 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 262.2 сая төгрөгийн төсөв баталснаас 247.0 сая төгрөгийг улсын төсвөөс 15.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 247.0 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 15.2 сая төгрөг нийт 262.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 251.8 сая төгрөгийг зарцуулж 10.4 сая төгрөгийг улсын төсөвт, 0.002 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 251.8 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 8.5 сая төгрөгөөр, норматив зардлыг 1.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.4 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.2 сая төгрөгөөр, дотоод албан томилолтын зардлыг 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 141 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 4 мэдээлэл, хугацаа болоогүй 2, мэдээллээгүй 4 мэдээлэл байна. 2021 оны 209.2 сая төгрөгийн 17 мэдээллийг ил тод байршуулахаас 209.2 сая төгрөгийн 17 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс 8.3 сая төгрөгийн албан шаардлага биелүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

1. Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
2. Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5.8 сая төгрөгийн алдааг залруулж, 1.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

- Орон нутгийн өмчийн тогтоолоор актлах шийдвэр гарсан 0.4 сая төгрөгийн тавилга эд хогшил актлаагүйг нөхөн актлуулж залруулсан.
- Татварын цахим сайтад шивэгдээгүй 5 иргэнтэй холбоотой 5.4 сая төгрөгийн гүйлгээ И баримтгүйг нөхөн шивүүлж залруулсан.

4.2 Төлбөрийн акт

- Ажилтанд 1.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал тушаал шийдвэргүй бодож олгосон нь Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам 1 дүгээр зүйлийн 1.2.1 "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх, хэмжилт эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу хөтлөөгүй, тооцоо бодоогүй 5.0 сая төгрөгийн зарлага гаргасан нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүллээ.
- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.1-д "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Нийгмийн даатгалын тайланг тооцоолсон цалингаас 3.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Тус цэцэрлэг нь 2020 онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор актлагдсан 0.4 сая төгрөгийн хөрөнгийг дахин актлуулахаар санал өгсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл, 77.2.1 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Тайлант онд 0.6 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт,

мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах. УСНББОУС1, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 1алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 141 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 4 мэдээлэл, хугацаа болоогүй 2, мэдээллээгүй 4 мэдээлэл байна. 2021 оны 209.2 сая төгрөгийн 17 мэдээллийг ил тод байршуулахаас 209.2 сая төгрөгийн 17 мэдээллийг хугацаа хоцроон ил тод бүрэн байршуулсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Алтай сумын хүүхдийн цэцэрлэг	8	16.6	2	5.8	1	1.1	5	9.7	0	0